



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТООЛЛОГО



2022 он

<http://www.ubstat.mn>

ОРШИЛ

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Монгол Улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 3 а, 3 б дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1 в, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1499 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2022 оны А/585 дугаар захирамжаар Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан тооллого явуулах удирдамж, зааврын дагуу 2022 оны мал, тэжээвэр амьтдын тооллогыг 12 сарын 07-ноос 17-ны өдрүүдэд дүүргийн хэмжээнд амжилттай зохион байгуулж явууллаа.

Энэхүү танилцуулгад орж байгаа статистикийн үзүүлэлтүүдийг дүүргийн мал, тэжээвэр амьтдын 2022 оны тооллогын мэдээллийг боловсруулж, Үндэсний Статистикийн хорооноос баталж зөвшөөрсөн, олон улсын стандартад нийцсэн аргачлалын дагуу тооцож, үр дүнг гаргалаа.

ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх: Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эхүүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 Адуу, үхэр = 1 бод, 1 тэмээ = 1.5 бод,

6 хонь = 1 бод, 8 ямаа = 1 бод

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ = 5 хонь, 1 адуу = 7 хонь, 1 үхэр = 6 хонь

1 хонь = 1 хонь, 1 ямаа = 0.9 хонь

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ- 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу- 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр- 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал – тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эх малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасаж гаргана.

Харьцангуй үзүүлэлтийг гаргахдаа оны эцсийн малын тоо гэх нийт малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлнэ.

Бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100 –гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл: Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25 Азарга - 12-15 Бух - 35-45 Хуц, ухна - 25-30

Малын зүй бус хорогдол: Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариуллага, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага:

1. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

2. Хүнсний хэрэглээний малын тоо= Алдсан мал+Зах зээлд борлуулсан+Аж ахуйн дотоодод хэрэглэсэн+(Бусдад шилжүүлсэн – Худалдаж авсан, шилжижирсэн).

Бусдад шилжүүлсэн>=Худалдаж авсан, шилжиж ирсэн

Учир нь худалдаж авсан эсвэл шилжиж ирсэн нэг хэсэг малаа идсэн байж болно. Идээгүй тохиолдолд тэнцэж байх учиртай.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, бог малынхыг гаргахдаа богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлэн тэжээлийн хангамжийг гаргадаг.

Үүний тулд дараахь итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Хадлан өвс	0.45
Таримал тэжээл	0.35
Даршны ургамал	0.25
Гартэжээл, хужир шүү	1.0
Төмс ногооны хаягдал	0.22
Үр тарианы хаягдал	0.9
Лай	0.4
Сүрэл	0.25


Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.



МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Малын тоо, бүтэц: Хан-Уул дүүрэгт 2022 оны мал тооллогоор нийт 42068 толгой мал тоологдсон нь 2021 оноос 3201 (7.5%) толгой малаар өссөн байна. Нийслэлийн хэмжээнд 2022 онд 442841 толгой мал тоологдсон бөгөөд 10.4 хувийг Хан-Уул дүүргийн мал эзэлж байна.

Зураг 1. Дүүргийн нийт малын тоо, оноор



Малын тоог таван төрлөөр өмнөх онтой харьцуулахад тэмээ 8 толгойгоор (72.7%), адуу 2825 толгойгоор (22.4%), үхэр 1079 толгойгоор (9.6%) тус тус өссөн бол хонь 468 толгойгоор (4.9%), ямаа 243 толгойгоор (2.6%) тус тус буурсан байна.

Иргэдийн хувийн мал 45167 толгой болж өмнөх оноос 2879 толгойгоор, аж ахуйн нэгж, байгууллагын мал 901 болж өмнөх оноос 322 толгойгоор өссөн байна.

Хүснэгт 1. Малын тоо, төрлөөр

Малын төрөл	2017	2018	2019	2020	2021	2022	Өсөлт, бууралт	
							Тоо	Хувь
Малын тоо, бүгд	38485	33208	38639	46090	42867	46068	3201	7.5
Тэмээ	1	3	3	7	11	19	8	72.7
Адуу	6247	5745	7589	11960	12597	15422	2825	22.4
Үхэр	12616	11231	11845	11900	11214	12293	1079	9.6
Хонь	9894	8576	10336	10231	9626	9158	-468	-4.9
Ямаа	9727	7653	8866	11992	9419	9176	-243	-2.6
Хонин толгойд шилжүүлснээр*	138078	123080	142523	176179	173621	199223.4	25602.4	114.7

* Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент: 1 тэмээ: 5 хонь, 1 адуу: 7 хонь, 1 үхэр: 6 хонь, 1 хонь: 1 хонь, 1 ямаа: 0.9 хонь

2022 онд дүүргийн 12-р хорооны мал 14.9 хувиар, 13-р хорооных 21.2 хувиар, 14-р хорооных 0.3 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Малын тоо, хороогоор

Хороо	2021	2022	Үүнээс: малын төрлөөр					Өсөлт, бууралт, хувь
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
12-р хороо	3766	4328	-	944	1993	653	738	14.9
13-р хороо	12090	14659	-	2663	5753	2651	3592	21.2
14-р хороо	27011	27081	19	11815	4547	5854	4846	0.3
Дүн	42867	46068	19	15422	12293	9158	9176	7.5

Дүүргийн хэмжээнд тоологдсон малын тоогоор 27081 толгой малаар 14-р хороо тэргүүлсэн бол хамгийн цөөн малтай нь 12-р хороо 4328 толгой малтай байна. 2022 онд нийт мал сүргийн 39.8 хувийг бог мал, 60.2 хувийг бод мал эзэлж байна. Нийт мал сүргийн бүтцэд таван төрлийн малын эзлэх хувийн жинг төрөл тус бүрээр нь дараахь хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт 3. Нийт малд эзлэх хувийн жин, малын төрлөөр

	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Нийт мал	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	0.0	0.02	0.0	0.01	0.008	0.015	0.02	0.04
Адуу	15.8	19.2	16.2	17.3	19.6	26.0	29.4	33.5
Үхэр	32.1	31.58	32.8	33.8	30.7	25.8	26.1	26.7
Хонь	26.5	25.6	25.7	25.8	26.8	22.2	22.5	19.9
Ямаа	25.6	23.6	25.3	23.0	22.892	26.0	22.0	19.9

Нийт мал сүргийн 0.04 хувийг тэмээ, 33.5 хувийг адуу, 26.7 хувийг үхэр, 19.9 хувийг хонь, 19.9 хувийг ямаа эзэлж байна. Малын нийт дүнд эзлэх хувийн жинг өмнөх онуудтай харьцуулахад адуу, үхрийн эзлэх хувийн жин нэмэгдэж, хонь, ямааны эзлэх хувийн жин багассан байна. Бог малын бүтцийн хувьд нийт бог малын 50.0 хувийг хонин сүрэг, 50.0 хувийг ямаан сүрэг эзэлж байна.


Малтай өрх, малчдын тоо: Хан-Уул дүүрэгт 2022 оны мал тооллогоор нийт 46068 толгой мал тоологдсон нь 2021 оноос 3201 (7.5%) толгой малаар өссөн байна. 2022 оны мал тооллогын дүнгээр хувийн малтай 802 өрх, үүний дотор 258 малчин өрх мал аж ахуй эрхэлж байна. Өнгөрсөн оноос малтай өрхийн тоо 38 өрхөөр нэмэгдэж, малчин өрхийн тоо 39 өрхөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. Малтай өрх, малчдын насны бүлгээр

он	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Түүний ам бүлийн тоо	Малчдын тоо	Насны бүлэг				Нийт малчдаас эмэгтэй
					15 хүртэлх насны	15-34 насны	35-59 насны	60-аас дээш насны	
2007	984	293	947	644	-	223	250	171	208
2008	854	300	1098	605	-	212	235	164	192
2009	933	178	547	178	-	29	106	43	62
2010	937	176	609	319	-	58	164	97	98
2011	877	287	375	421	-	19	210	112	158
2012	840	56	201	110	-	31	63	16	50
2013	809	100	356	185	-	42	125	18	85
2014	728	104	364	209	-	59	122	28	100
2015	816	106	385	216	-	57	140	19	95
2016	836	206	704	389	-	85	252	52	164
2017	809	153	610	281	6	79	163	33	108
2018	700	182	602	288	-	75	185	28	117
2019	674	232	851	352	-	77	245	30	145
2020	729	210	757	293	-	55	212	26	105
2021	764	219	800	318	-	62	245	11	129
2022	802	258	950	368	-	67	275	26	139

Малчдыг насны бүлгээр авч үзвэл 18.2 хувь нь 15-34 насны, 74.7 хувь нь 35-аас 59 насны, 7.1 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Нийт малчдын 139 буюу 37.8 хувь нь эмэгтэй малчид байна.

Зураг 2. Малчдын тоо, насны бүлгээр



Дүүргийн малчин өрх, малчдын тоог өнгөрсөн онтой харьцуулахад малчин өрхийн тоо 39 өрх (17.8%), малчдын тоо 50 хүнээр (15.7%) нэмэгдсэн байна.

Малчин өрхийн 60.5 хувийг цахилгаан эх үүсвэртэй, 50.0 хувийг телевизортой өрх эзэлж байна.

"Амины мал"-ын тоо: Иргэдийн хувийн өмчийн малын тоо 2022 онд 45167 толгой болж, нийт малын 98.0 хувийг эзэлж байна. Тоологдсон адууны 99.4 хувь, үхрийн 99.1 хувь, хонины 98.2 хувь, ямааны 94.1 хувийг хувийн өрхийн мал эзэлж байна.

Хүснэгт 5. Малтай өрхийн тоо, малын бүлэглэлтээр, 2022 он

Малын бүлэглэлт	Малтай өрхийн тоо	Ам бүлийн тоо	Амины малын тоо	Үүнээс: малын төрлөөр				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
10 хүртэл	219	659	1222	-	165	1042	8	7
11-30	228	803	4409	-	1559	2562	135	153
31-50	113	387	4465	11	2101	1958	152	243
51-100	138	503	9668	-	5038	3547	353	730
101-200	60	228	8226	-	3673	1567	1417	1569
201-500	35	155	10984	8	2481	1273	3631	3591
501-999	8	23	5153	-	262	188	2551	2152
1000-1499	1	2	1040	-	50	50	750	190
1500-2000	-	-	-	-	-	-	-	-
Дүн	802	2760	45167	19	15329	12187	8997	8635

Дүүргийн малтай нэг өрхөд 56.3 толгой мал, бодод шилжүүлснээр 37.6 толгой мал ногдож байна. Малтай өрхийн ам бүлийн нэг хүнд 16.4 толгой мал, бодод шилжүүлснээр 10.9 толгой мал ногдож байна.

Мал төллөлт, төл бойжилт: 2022 онд 14882 хээлтэгч мал төллөж, 14884 төл гарсны 14547 төл (97.7%) нь бойжиж байна. Бойжсон төлийн тоо өмнөх оноос 3417 толгойгоор (30.7%) өссөн.

Зураг 3. Бойжуулсан төл, оноор



Бойжуулсан нийт төлийн 20.7 хувийг унага, 30.1 хувийг тугал, 25.7 хувийг хурга, 23.5 хувийг ишиг эзэлж байна.

Хүснэгт 6. Төл бойжилт, төрлөөр

	2021	2022	Үүнээс:				
			Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	12075	14884	-	3086	4457	3819	3522
Бойжсон төл	11130	14547	-	3010	4378	3745	3414
Хорогдсон төл	945	337	-	76	79	74	108
Бойжилтын хувь	92.2	97.7	-	97.5	98.2	98.1	96.9

2022 оны мал тооллогоор нийт 14884 гарсан төлийн 337 (2.3%) толгой нь хорогдож, төл бойжилт 97.7 хувьтай байна. Хорогдсон төл малын тоо 2021 оныхоос 608 толгойгоор буурсан. Нийт хорогдсон төлийн 22.6 хувийг унага, 23.4 хувийг тугал, 22.0 хувийг хурга, 32.0 хувийг ишиг эзэлж байна.

Хүснэгт 7. Төл бойжилт, төлийн орлого, зарлага, төрлөөр

Төрөл	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж авсан	Шилжиж ирсэн	Худалдсан	Шилжүүлсэн
Ботго	-	-	-	-	-	-	-	-
Унага	3086	3086	76	3010	66	552	420	194
Тугал	4457	4457	79	4378	126	193	1159	105
Хурга	3817	3819	74	3745	214	270	623	511
Ишиг	3522	3522	108	3414	38	312	774	370
Бүгд	14882	14884	337	14547	444	1327	2976	1180

2022 онд нийт 14547 төл бойжуулсан, 444 төл бусдаас худалдан авсан, 1327 төл шилжиж ирсэн байна. Мөн 2976 төлийг бусдад худалдаж, 1180 төлийг шилжүүлсэн байна. 2022 онд худалдсан төлийг төрлөөр нь авч үзвэл: унага 420 толгой, тугал 1159 толгой, хурга 623 толгой, ишиг 774 толгой төл худалджээ.

Бэлэн тоологдсан төл : 2022 оны мал тооллогоор бэлэн тоологдсон төлийн тоо 12162 толгой болж өнгөрсөн оныхоос 2796 толгой (29.9%) төлөөр өссөн байна.

Хүснэгт 8. Бэлэн тоологдсон төл, төрлөөр

Төрөл	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2022/2021	
								хувь	зөрүү
Ботго	-	-	-	-	1	5	-	-	-
Унага	1069	1010	712	1701	2193	1905	3014	158.2	1109
Тугал	3433	4116	3028	3898	3599	2913	3433	117.9	520
Хурга	3223	3369	2386	3432	3230	2489	3095	124.3	606
Ишиг	2424	2973	1746	2810	2873	2054	2620	127.6	566
Бүгд	10149	11468	7872	11841	11896	9366	12162	129.9	2796

Том малын зүй бус хорогдол: Оны эхний малын 1.4 хувьтай тэнцэх 596 толгой том мал зүй бусаар хорогдож, өмнөх оноос хорогдол 2404 толгойгоор буурсан. Хорогдсон нийт малын 16.1 хувийг адуу, 20.0 хувийг үхэр, 21.0 хувийг хонь, 42.9 хувийг ямаа эзэлж байна. Том малын зүй бус хорогдлын 32 толгой (5.4%) мал өвчнөөр хорогджээ.

Хүснэгт 9. Том малын зүй бус хорогдол

Үзүүлэлт	2021	2022	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал	3000	596	-	96	119	125	256
Үүнээс: Өвчнөөр хорогдсон	14	32	-	2	4	12	14

Малын хэрэглээний орлого зарлага: 2022 онд оны эхний нийт малын 1773 (4.1%) толгой малыг хүнсний хэрэглээнд зарцуулсан байна. Хүнсэнд зарцуулсан малын 25.5 хувийг хонь, 21.4 хувийг ямаа, үлдсэн 53.1 хувийг бод мал эзэлж байна.

Хүснэгт 10. Малын хэрэглээний орлого, зарлага, төрлөөр

Төрөл	Орлого			Хасагдсан					
	Худалдаж авсан	Шилжиж ирсэн	Бэлэн тоологдсон төл	Шилжүүлсэн	Алдсан, цулгайлагдса нолдохгүй байгаа	Зах зээлд борлуулсан	Хүнсэнд хэрэглэсэн	Зүй бус хорогдол	
Тэмээ	8	-	-	-	-	-	-	-	
Адуу	799	2493	3014	2077	68	998	242	96	
Үхэр	1016	643	3433	909	41	2244	700	119	
Хонь	600	789	3095	2648	-	1727	452	125	
Ямаа	873	947	2620	2799	7	1242	379	256	
Дүн	3296	4872	12162	8433	116	6211	1773	596	

Дээрх хүснэгтээс харахад энэ жилийн малын орлого талд тооллогоор худалдаж авсан 3296 толгой, бэлэн тоологдсон төл 12162 толгой, шилжиж ирсэн 4872 толгой мал байна. Харин шилжүүлсэн 8433 толгой мал, зүй бусаар 596 толгой мал хорогдсон, хүнсэнд хэрэглэсэн 1773 толгой мал, 6211 толгой малыг зах зээлд борлуулсан нь зарлага талын үзүүлэлтийг бүрдүүлж байна.

Хүснэгт 11. Малын тооны өөрчлөлтөд нөлөөлсөн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022	2022/2021	
						тоо	Хувь
Бэлэн тоологдсон төл	7872	11841	11896	9366	12162	2796	129.9
Том малын зүй бусын хорогдол	1775	383	1323	3000	596	-2404	-80.1
Хээлтэгч малын тоо	16737	17716	20736	20446	20878	432	102.1
Хээл хаясан хээлтэгч	1084	519	450	1066	359	-707	-66.3
Сувайрсан хээлтэгч	4531	2800	3084	5271	3470	-1801	-34.2

2022 онд бэлэн тоологдсон төл 29.9 хувиар, хээлтэгч малын тоо 2.1 хувиар өсөж, том малын зүй бусын хорогдол 80.1 хувиар, сувайрсан хээлтэгч 34.2 хувиар, хээл хаясан хээлтэгч 66.3 хувиар буурсан байна.

Малын хээл хаялт, сувайралт: 2022 онд оны эхний хээлтэгч малын 18.7 хувьтай тэнцэх хээлтэгч мал төл өгөөгүй ба үүний 3470 эх мал сувайрсан, 359 эх мал хээл хаясан байна. Энэ нь өмнөх оноос сувайрсан мал 1801 толгойгоор, хээл хаясан мал 707 толгойгоор буурсан байна.

Хүснэгт 12. Сувайрсан болон хээл хаясан мал, төрлөөр

Төрөл	Төл өгөөгүй хээлтэгч мал			Үүнээс:						
				Сувайрсан			Хээл хаясан			
	2020	2021	2022	2020	2021	2022	2020	2021	2022	
Ингэ	-	-	-	-	-	-	-	-	-	-
Гүү	781	1522	1199	707	1238	1136	74	284	63	
Үнээ	954	1669	1171	888	1564	1118	66	105	53	
Эм хонь	961	1278	664	747	974	578	214	304	86	
Эм ямаа	838	1868	795	742	1495	638	96	373	157	
Бүгд	3534	6337	3829	3084	5271	3470	450	1066	359	

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Дүүргийн нийт мал сүргийн 12162 (26.4%) нь төл мал, 20878 (45.3%) нь хээлтэгч мал, 968 нь хээлтүүлэгч мал байна. Малын үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад дүүргийн хувьд нэг хээлтүүлэгчид дунджаар 72 эм хонь, 61 эм ямаа ногдож, хээлтүүлгийн тохироо алдагдсан байна.

Хүснэгт 13. Хээлтүүлэгч малын тоо


Төрөл	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	Өсөлт, бууралт /тоо/
Буур	2	-	-	-	-	-	-	-	-	-
Азарга	331	345	418	325	350	424	557	593	709	116
Бух	98	97	114	106	110	110	110	113	123	10
Хуц	114	71	56	56	41	47	52	46	61	15
Ухна	91	77	55	48	36	39	54	43	75	32
Бүгд	636	590	643	535	537	620	773	795	968	173

Хээлтэгч мал: 2022 оны мал тооллогоор 20878 толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оноос 432 толгой (2.1%) малаар өссөн байна.

Хүснэгт 14. Хээлтэгч мал, төрлөөр

Төрөл	2017	2018	2019	2020	2021	2022	Өсөлт, бууралт	
							тоо	хувь
Ингэ	1	1	-	1	-	-	-	-
Гүү	1966	2158	2630	3841	4494	5409	915	120.4
Үнээ	6259	6105	6000	5711	5983	6423	440	107.4
Эм хонь	4782	4434	5105	5132	4942	4408	-534	89.2
Эм ямаа	4629	4039	3981	6051	5027	4638	-389	92.3
Бүгд	17637	16737	17716	20736	20446	20878	432	102.1

Зураг 4. Хээлтэгч малын тоо



2022 онд дүүргийн нийт малын 45.3 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Үүнд: адуун сүргийн 35.1 хувь, үхэр сүргийн 52.2 хувь, хонин сүргийн 48.1 хувь, ямаан сүргийн 50.5 хувийг хээлтэгч мал эзэлж байна.

Бэлтгэсэн хадлан тэжээл: Дүүргийн хэмжээнд 2022 онд 11126.7 тонн хадлан, гар тэжээл 1163.6 тонн, хужир шүү 287.4 тонныг тус тус бэлтгэсэн байна. 2021 онтой харьцуулахад хадлан 1261.2 тонн (10.2%), хужир шүү 66.2 тонн (18.7%)-оор буурсан бол гар тэжээл 65.4 тонн (5.9%)-оор нэмэгдсэн байна.

Хүснэгт 15. Бэлтгэсэн хадлан тэжээл, тн

Бэлтгэсэн хадлан тэжээл	2017	2018	2019	2020	2021	2022	Өсөлт, бууралт
Хадлан	5464.5	5205.1	5599.0	6664.2	12387.9	11126.7	89.8
Гар тэжээл	1915.3	1282.9	1265.5	1235.5	1098.2	1163.6	105.9
Хужир шүү	204.4	102.4	281.0	146.6	353.6	287.4	81.3

2022 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор 238 худаг, 1077 малын хашаа тоологдсон нь 2021 онтой харьцуулахад худаг 0.4 хувиар, малын хашаа 14.3 хувиар буурсан байна.

Тэжээвэр амьтад: Мал, тэжээвэр амьтдын 2022 оны тооллогоор 71 өрх, 13 аж ахуйн нэгжийн 3785 гахай, 3600 мянган загас, туулай 140, 611826 шувуу, үүнээс 611724 тахиа, цацагт хяруул 18, галуу 71, бөднө 13, усан гахай 270, зөгийн 4 бүл тус тус тоологдсон байна. Өмнөх онтой харьцуулахад шувуу болон тахианы тоо 37.5 хувиар өссөн бол гахайн тоо 6.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 16. Тэжээвэр амьтдын тоо

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
Гахай	4174	3753	3847	3610	4037	3785
Шувуу	360722	391542	427437	483300	445390	611826
Үүнээс: тахиа	360201	391114	427062	482860	444701	611724
Зөгийн бүл	-	-	-	-	-	4

Гахай, шувуу тэжээдэг иргэд, аж ахуйн нэгжүүд 2022 онд 28.4 тонн гахайн мах, 168.9 тонн шувууны мах, 99.2 сая ширхэг өндөг нийт 44.6 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Гэрийн тэжээвэр муур, нохой: Хан-Уул дүүргийн 25 хороонд гэрийн тэжээвэр 4285 нохой, 208 муур байна. Бүртгэлийн дүнг өмнөх оны дүнтэй харьцуулахад нохойн тоо 449 (9.5%)-өөр, муурны тоо 151 (42.1%)-ээр буурсан байна.

Хүснэгт 17. Тэжээвэр нохой, муурны тоо, хороогоор

Хороо	Нохой			Муур		
	2021	2022	Өсөлт, бууралт	2021	2022	Өсөлт, бууралт
1-р хороо	31	32	103.2	2	6	3 дах
2-р хороо	23	19	82.6	7	7	-
3-р хороо	37	21	56.7	8	9	112.5
4-р хороо	299	209	69.9	2	2	-
5-р хороо	325	263	80.9	3	3	-
6-р хороо	325	382	117.5	9	14	155.5
7-р хороо	199	203	102.0	10	10	-
8-р хороо	601	599	99.7	11	5	45.4
9-р хороо	661	612	92.6	5	5	-
10-р хороо	316	299	94.6	21	12	57.1
11-р хороо	11	5	45.4	7	5	71.4
12-р хороо	471	358	76.0	18	7	38.9
13-р хороо	516	387	75.0	161	49	30.4
14-р хороо	242	219	90.5	48	29	60.4
15-р хороо	64	58	90.6	13	12	92.3
16-р хороо	514	493	95.9	1	3	3 дах
17-р хороо	33	37	112.1	16	4	25.0
18-р хороо	16	24	150.0	5	7	140.0
19-р хороо	27	27	-	1	1	-
20-р хороо	14	8	57.1	8	4	50.0
21-р хороо	9	6	66.7	3	3	-
22-р хороо	-	5	-	-	4	-
23-р хороо	-	4	-	-	4	-
24-р хороо	-	5	-	-	2	-
25-р хороо	-	10	-	-	1	-
Нийт	4734	4285	90.5	359	208	57.9

*дах -дахин

Тэжээвэр нохойны тоог хороогоор авч үзвэл 1, 6, 7, 17, 18-р хорооны нохойны тоо 2.0 хувиас дээш өссөн бол бусад хорооны нохойны тоо буурсан байна. Нийт бүртгэгдсэн тэжээвэр нохойны 14.3 хувь нь 9-р хороонд, 14.0 хувь нь 8-р хороонд байна.

Тэжээвэр муурны тоо 1, 3, 6, 16, 18-р хороонд 12.5 хувиас дээш өссөн, бусад хороонд 7.7 - 50.0 хувиар буурсан. Харин 2, 4, 5, 7, 9, 19, 21-р хорооны муурны тоо өмнөх оны түвшинд байна.

ДУГНЭЛТ

Хан-Уул дүүрэгт 2022 оны мал тооллогоор нийт 46068 толгой мал тоологдсон нь 2021 оноос 3201 (7.5%) толгой малаар өссөн байна. Малын тоо толгойн өсөлтөнд тэмээ 8 (72.7%), адуу 2825 толгой (22.4%), үхэр сүрэг 1079 толгойгоор (9.6%) тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. 2022 онд бог малын бүтцэд нийт бог малын 50.0 хувийг хонин сүрэг, 50.0 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Дүүргийн хэмжээнд малтай 3 хороонд 802 өрх, 8 ААН-ийн нийт 46068 толгой мал тоологдсоныг малын төрөл тус бүрээр авч үзвэл:

- ✓ тэмээ 19
- ✓ адуу 15422
- ✓ үхэр 12293
- ✓ хонь 9158
- ✓ ямаа 9176 толгой байна.

Малын таван төрлөөр өмнөх онтой харьцуулахад тэмээ 8 толгой (72.7%), адуу 2825 толгойгоор (22.4%), үхэр 1079 толгойгоор (9.6%) тус тус өссөн бол хонь 468 толгойгоор (4.9%), ямаа 243 толгойгоор (2.6%) тус тус буурсан байна.

Нийт мал сүргийн 0.04 хувийг тэмээ, 33.5 хувийг адуу, 26.7 хувийг үхэр, 19.9 хувийг хонь, 19.9 хувийг ямаа тус тус эзэлж байна. Нийт малын 45.3 хувийг хээлтэгч мал, 26.4 хувийг төл мал эзэлж байна. 2022 оны мал тооллогоор нийт 14884 төл гарсны 337 (2.3%) толгой нь хорогдож, төл бойжилт 97.7 хувьтай байна.

2022 онд дүүргийн хэмжээнд 71 өрх, 13 аж ахуйн нэгж байгууллагын 3785 гахай, 611826 шувуу, үүнээс 611724 тахиа тоологджээ. 2022 оны дүүргийн нохой, муурны бүртгэлээр гэрийн тэжээвэр нохой 4285, муур 208 бүртгэгдсэн байна.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр

Хүснэгт 1. Тэмээ, толгой

Хороо	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
11	1	1	-	1	1	-	-	-	-	-
12	-	-	-	-	-	-	-	-	-	-
13	1	-	-	-	-	-	-	2	-	-
14	2	14	1	6	-	3	3	5	11	19
Дүн	4	15	1	7	1	3	3	7	11	19

Хүснэгт 2. Адуу, толгой

Хороо	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
4	8	11	14	12	2	-	-	-	-	-
5	3	1	2	5	6	-	-	-	-	-
6	-	-	-	-	4	-	-	-	-	-
7	76	27	41	162	-	-	-	-	-	-
8	2	125	115	154	109	-	-	-	-	-
9	9	28	11	4	17	-	-	-	-	-
10	137	27	23	67	29	-	-	-	-	-
11	1	3	1	6	-	-	-	-	-	-
12	264	424	430	634	434	843	773	799	833	944
13	1412	1707	1806	1941	1884	1460	1676	2140	2051	2663
14	3474	3542	3475	4466	3762	3442	5140	9021	9713	11815
16	2	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	5388	5895	5918	7451	6247	5745	7589	11960	12597	15422

Хүснэгт 3. Үхэр, толгой

Хороо	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
4	152	139	177	155	134	-	-	-	-	-
5	144	126	155	213	146	-	-	-	-	-
6	41	68	76	55	75	-	-	-	-	-
7	16	17	25	36	-	-	-	-	-	-
8	70	183	258	358	202	-	-	-	-	-
9	100	104	162	196	250	-	-	-	-	-
10	290	211	236	253	220	-	-	-	-	-
11	31	52	58	64	45	-	-	-	-	-
12	1776	2182	2626	2686	2571	2376	2111	2028	1873	1993
13	3594	4170	4588	4321	4820	4754	5174	5259	4944	5753
14	3320	3821	3633	3906	4140	4101	4560	4613	4397	4547
16	49	37	49	31	13	-	-	-	-	-
Дүн	9583	11110	12043	12274	12616	11231	11845	11900	11214	12293

Хүснэгт 4. Хонь, толгой

Хороо	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
6	171	185	221	24	36	-	-	-	-	-
7	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	-	-	128	164	34	-	-	-	-	-
9	-	-	-	-	299	-	-	-	-	-
10	239	269	297	196	78	-	-	-	-	-
11	43	20	-	-	-	-	-	-	-	-
12	1173	1043	986	714	1086	576	768	747	371	653
13	3628	5435	4731	3986	3268	2910	2972	2831	2469	2651
14	6320	7380	3581	4874	5093	5090	6596	6653	6786	5854
16	10	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	11586	14332	9944	9958	9894	8576	10336	10231	9626	9158

Хүснэгт 5. Ямаа, толгой

Хороо	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
4	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	142	124	148	34	46	-	-	-	-	-
7	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	-	-	194	174	100	-	-	-	-	-
9	-	-	-	-	460	-	-	-	-	-
10	527	478	341	161	108	-	-	-	-	-
11	28	6	-	-	-	-	-	-	-	-
12	2084	1849	2154	1685	1848	1270	1254	1315	689	738
13	3275	4004	3960	3380	3583	2889	3031	3494	2626	3592
14	4175	4873	2817	3736	3582	3494	4581	7183	6104	4846
16	200	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	10431	11334	9614	9170	9727	7653	8866	11992	9419	9176

Хүснэгт 6. Хээлтэгч малын тоо төрлөөр, тоо

Он	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Хонь	Ямаа
2010	15110	1	952	3856	4473	5828
2011	14600	14	976	4280	4220	5110
2012	16910	15	1263	4251	5845	5536
2013	16569	2	1365	4507	5491	5204
2014	19471	8	1685	5146	7137	5495
2015	16572		1591	5585	4833	4563
2016	17812	4	2207	6072	4957	4572
2017	17637	1	1966	6259	4782	4629
2018	16737	1	2158	6105	4434	4039
2019	17716	0	2630	6000	5105	3981
2020	20736	1	3841	5711	5132	6051
2021	20446	-	4494	5983	4942	5027
2022	20878	-	5409	6423	4408	4638

Хүснэгт 7. Хээлтүүлэгч малын тоо, төрлөөр, толгой

Хороо	Бүгд	Үүнээс:				
		Буур	Азарга	Бух	Хуц	Ухна
2007	458	-	168	63	104	122
2008	400	-	117	69	116	120
2009	528	-	201	64	126	137
2010	518	-	319	73	66	60
2011	499	1	290	67	92	49
2012	584	1	318	85	88	92
2013	614	-	346	92	86	90
2014	636	2	331	98	114	91
2015	590	-	345	97	71	77
2016	643	-	418	114	56	55
2017	535	-	325	106	56	48
2018	537	-	350	110	41	36
2019	620	-	424	110	47	39
2020	773	-	557	110	52	54
2021	795	-	593	113	46	43
2022	968	-	709	123	61	75

Хүснэгт 8. Бойжсон төл, төрлөөр, толгой

Он	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
2007	11427	5	205	2465	3922	4830
2008	12492	-	271	2108	4861	5252
2009	14069		351	2242	5225	6251
2010	5630		286	2454	1632	1258
2011	11443	5	620	2850	3569	4399
2012	12073	5	825	3185	3984	4074
2013	15805	6	937	3578	5564	5720
2014	13945		929	3641	4509	4866
2015	15988	4	1002	4103	5835	5044
2016	13181	1	1211	4341	4081	3547
2017	14180	2	1469	5038	4073	3598
2018	11044	-	931	4055	3327	2731
2019	11841	-	1701	3898	3432	2810
2020	12025	-	1703	4373	3181	2768
2021	11130	-	1796	3490	3308	2536
2022	14547	-	3010	4378	3745	3414

Хүснэгт 9. Том малын зүй бус хорогдол, төрлөөр, толгой

Он	Бүгд	адуу	үхэр	хонь	ямаа
2007	122	4	38	42	38
2008	247	6	121	51	69
2009	166	17	37	44	68
2010	20754	862	1373	8380	10139
2011	249	17	116	48	68
2012	165	3	74	44	44
2013	231	20	89	72	50
2014	293	9	89	63	132
2015	552	36	152	120	244
2016	751	83	281	187	200
2017	1070	142	395	280	253
2018	1775	287	432	477	579
2019	383	88	103	104	88
2020	1323	98	300	535	390
2021	3000	456	399	1071	1074
2022	596	96	119	125	256

Хүснэгт 10. Хээл хаясан хээлтэгч малын тоо, толгой

Он	Бүгд	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
2007	353	45	23	170	115
2008	451	29	55	112	255
2009	518	14	66	128	310
2010	1034	39	79	373	543
2011	245	28	60	75	82
2012	373	16	42	130	185
2013	349	23	34	185	107
2014	367	17	31	179	140
2015	233	22	30	69	112
2016	762	70	57	254	381
2017	1936	277	554	649	456
2018	1084	260	186	213	425
2019	519	40	75	250	154
2020	450	74	66	214	96
2021	1066	284	105	304	373
2022	359	63	53	86	157

Хүснэгт 11. Сувайрсан хээлтэгч малын тоо, толгой

Он	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
2007	1637	1	45	261	502	828
2008	1788	1	55	685	247	800
2009	2329	1	82	671	620	955
2010	1478		137	475	321	545
2011	1089		136	331	253	369
2012	1544	4	204	525	249	562
2013	1234	1	202	501	334	196
2014	2289	1	370	619	748	551
2015	2155		309	763	609	474
2016	2710	1	436	1178	436	659
2017	2313	-	405	946	460	502
2018	4531	-	776	1549	1101	1105
2019	2800	-	535	918	607	740
2020	3084	-	707	888	747	742
2021	5271		1238	1564	974	1495
2022	3470	-	1136	1118	578	638

Хүснэгт 12. Малтай өрхийн бүлэглэлт, малын тооны бүлгээр

Малын тооны бүлэг	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
10 хүртэл	345	357	325	330	328	267	105	200	224	219
11-30	238	246	261	249	249	201	127	209	222	228
31-50	84	76	81	90	70	87	58	99	112	113
51-100	63	60	70	90	85	80	70	114	115	138
101-200	34	40	41	37	35	34	26	63	56	60
201-500	37	43	31	30	32	20	20	30	24	35
501-999	7	7	5	8	8	9	7	11	8	8
1000-1499	1	3	2	1	1	1	1	2	3	1
1500-2000	-	-	-	1	1	1	1	1	-	-
Дүн	809	832	816	836	809	700	415	729	764	802

Хүснэгт 13. Малтай болон малчин өрхийн тоо

он	Малтай өрх	Үүнээс:Малчин өрх	Малчдын тоо	Үүнээс:Эмэгтэй
2006	926	124	210	41
2007	984	293	644	208
2008	851	300	605	192
2009	933	178	3187	547
2010	1034	179	324	98
2011	877	283	648	274
2012	956	56	110	50
2013	809	100	185	85
2014	832	104	209	100
2015	816	106	216	95
2016	836	206	389	164
2017	809	153	281	108
2018	700	182	288	117
2019	674	232	352	145
2020	729	209	293	105
2021	764	219	318	129
2022	802	258	368	139

Хүснэгт 14. Малчдын насны бүрэлдэхүүн

Насны бүлэг	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
6-14					6					
15-34	42	59	57	85	79	75	77	55	62	67
35-54 насны эм, 35-59 насны эр	125	122	140	252	163	185	245	212	238	275
55 ба түүнээс дээш насны эм, 60 ба түүнээс дээш насны эр	18	28	19	52	33	28	30	26	18	26
Дүн	185	209	216	389	281	288	352	293	318	368

Хүснэгт 15. Малчин өрхийн соёл ахуйн зарим үзүүлэлт

Өрхийн үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Цахилгаан гэрэлтэй	87	103	101	136	154	123	162	158	150	156
Телевизортой	74	96	97	135	121	108	153	146	141	129
Автомашинтай	117	125	223	357	259	267	324	405	590	429
Мотоциклтэй	40	7	32	39	36	64	70	67	108	97

Хүснэгт 16. Малын хашаа, худгийн тоо

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Хашаа	961	887	977	1005	961	1058	970	897	1256	1079
Худаг	141	187	267	206	203	234	195	246	239	238

Хүснэгт 17. Тэжээвэр амьтдын тоо

Он	Гахай	Үүнээс:Мэгж	Шувуу	Үүнээс: өндөглөгч
2007	4460	719	171692	112836
2008	5137	688	215354	177893
2009	6818	642	240915	157141
2010	8121	772	252069	181102
2011	5976	737	379971	310338
2012	5952	794	284729	269158
2013	6555	1042	240672	240570
2014	7901	1138	274887	274676
2015	5926	752	269307	218506
2016	5007	101	322527	318479
2017	4174	30	360722	250009
2018	3753	467	391542	360344
2019	3847	576	427437	349819
2020	3610	520	483300	401661
2021	4037	584	445390	376904
2022	3785	528	611826	435325

Хүснэгт 18. Гахай, шувууны аж ахуйн бүтээгдэхүүн

Он	Гахайн мах (тн)	Шувууны мах(кг)	Өндөг (мян.ш)
2007	15.8	78200.0	28209.0
2008	21.6	68600.0	45200.0
2009	60.0	56466.0	28593.3
2010	80.0	64855.0	37886.4
2011	216.3	226432.8	55438.0
2012	133.2	59900.0	42642.9
2013	199.2	69686.0	22239.3
2014	360.9	132642.0	48190.9
2015	37.0	89120.0	43238.3
2016	296.0	119630.0	55801.3
2017	88.2	91800.0	71957.3
2018	329.0	115800.0	111935.0
2019	322.5	127440.0	84424.0
2020	187.6	156745.0	105150.6
2021	167.0	210345.0	107226.9
2022	33.4	180590.0	102395.4

Хүснэгт 19. Гэрийн тэжээвэр нохой, муурны тоо, оноор

Он	Нохой		Муур	
	Бүгд	үүнээс: орон сууцанд	Бүгд	үүнээс: орон сууцанд
2007	4853	128	80	3
2008	4927	128	91	3
2009	4902	129	139	11
2010	4554	124	143	13
2011	4977	119	153	14
2012	5019	177	164	18
2013	5695	91	184	20
2014	5897	119	215	21
2015	5804	94	233	17
2016	5912	89	118	10
2017	5540	86	128	10
2018	5630	183	222	16
2019	5385	110	151	26
2020	5126	158	230	39
2021	4734	254	359	63
2022	4285	261	208	65

Хүснэгт 20. Гэрийн тэжээвэр нохойны тоо, хороогоор

Хороо	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
1	22	18	20	21	13	22	24	23	21	31	32
2	40	42	63	37	37	28	33	15	20	23	19
3	16	14	16	13	13	13	55	19	31	37	21
4	375	332	359	350	316	320	257	300	300	299	209
5	331	408	438	439	455	456	420	420	328	325	263
6	562	558	484	500	475	473	353	360	370	325	382
7	431	354	364	321	371	351	354	299	220	199	203
8	876	836	852	822	761	753	786	572	547	601	599
9	644	642	724	802	752	752	798	765	750	661	612
10	356	356	347	458	628	634	505	499	499	316	299
11	99	100	106	105	75	72	41	39	11	11	5
12	138	527	507	402	434	121	396	461	409	471	358
13	184	371	515	494	585	590	513	399	421	516	387
14	327	518	477	483	544	527	561	667	619	242	219
15	23	17	20	23	26	23	30	3	3	64	58
16	595	602	605	534	427	405	504	494	494	514	493
17								7	28	33	37
18								8	10	16	24
19								20	27	27	27
20								8	9	14	8
21								7	9	9	6
22								-	-	-	5
23								-	-	-	4
24								-	-	-	5
25								-	-	-	10
	5019	5695	5897	5804	5912	5540	5630	5385	5126	4734	4285

Хүснэгт 21. Гэрийн тэжээвэр муурын тоо, хороогоор

Хороо	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
1	7	10	10	8	3	6	3	1	3	2	6
2	2	4	6	3	3	-	2	2	5	7	7
3	0	3	3	3	3	3	3	2	6	8	9
4	2	4	4	4	-	2	54	4	4	2	2
5	5	12	17	17	-	17	7	7	5	3	3
6	27	3	13	9	10	9	6	6	12	9	14
7	9	5	9	5	7	7	4	6	4	10	10
8	15	15	13	15	13	5	5	8	10	11	5
9	2	6	4	5	-	-	3	3	4	5	5
10	1	20	18	39	-	6	11	11	11	21	12
11	9	5	6	6	2	3	6	3	6	7	5
12	18	37	28	27	9	2	42	0	8	18	7
13	27	49	70	59	39	37	54	73	123	161	49
14	26	4	6	24	27	22	20	4	4	48	29
15	1	1	2	3	1	3	2	1	1	13	12
16	13	6	6	6	1	6	-	0	0	1	3
17	-	-	-	-	-	-	-	0	17	16	4
18	-	-	-	-	-	-	-	0	2	5	7
19	-	-	-	-	-	-	-	1	1	1	1
20	-	-	-	-	-	-	-	8	2	8	4
21	-	-	-	-	-	-	-	11	2	3	3
22								-	-	-	4
23								-	-	-	4
24								-	-	-	2
25								-	-	-	1
Бүгд	164	184	215	233	118	128	222	151	230	359	208

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах
ТОГЛООМ



Валютын ханш




аппликейшнаас

СТАТИСТИКИЙН

МЭДЭЭЛЛЭЭ АВААРАЙ

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network



www.facebook.com/StatisticMongolia/



www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn